

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Төр захиргааны Автобааз УТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/42/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он

Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр

Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: С.Гантөгс

Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn

Аудитор: Э.Ундармаа

Утас: 325093 Цахим хаяг: undarmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15 № 310
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ
АВТОБААЗ УТҮГ-ЫН ДАРГА
Э.БОЛОР-ЭРДЭНЭ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Нийслэлийн Төр захиргааны Автобааз УТҮГ 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Нийслэлийн Төр захиргааны Автобааз УТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн “Дуудлагын автомашины үйлчилгээний тариф шинэчлэх” зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг 2023 онд зохион байгуулж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/56 тоот захирамжаар батлуулан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхээр болсон.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус газрын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Бүртгэлтэй газрын хэмжээ зөрүүтэй, авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, ашиглагдахгүй тээврийн хэрэгслүүд, стандартын шаардлага хангахгүй санхүүгийн программын асуудлыг шийдвэрлэх зэрэг зөрчлүүд илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	245,987,212.46	43,820,305.82
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11,110,189.83	5,136,084.40
1.1.02	Дансны авлага	57,122,764.33	14,728,472.37
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	117,574.00	643,442.37
1.1.04	Бусад авлага	34,500.00	760,000.00
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.06	Бараа материал	177,602,184.30	23,955,749.05
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0	0
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	0	0
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	245,987,212.46	43,820,305.82
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.01	Үндсэн хөрөнгө	3,654,851,972.81	3,296,800,081.19
1.2.02	Биет бус хөрөнгө	90,367,919.67	90,367,919.67
1.2.03	Биологийн хөрөнгө	-	-
1.2.04	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,745,219,892.48	3,387,168,000.86
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,991,207,104.94	3,430,988,306.68
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.01	Дансны өглөг	886,000.00	27,208,771.00
2.1.1.02	Цалингийн өглөг	-	-
2.1.1.03	Татварын өр	25,769,715.00	47,704,348.12
2.1.1.04	НДШ - ийн өглөг	3,239,217.74	
2.1.1.05	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	1,577,246,596.73	1,118,782,899.15
2.1.1.09	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	3,875,698.00	0
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,611,017,227.47	1,193,696,018.27
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.01	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.02	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,611,017,227.47	1,193,696,018.27
2.3	Эздийн өмч	-	-
2.3.01	Өмч: - төрийн	2,841,983,847.16	2,841,983,847.16
2.3.02	- хувийн	-	-
2.3.03	- хувьцаат	-	-
2.3.04	Халаасны хувьцаа	-	-
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,146,129,535.27	1,146,129,535.27
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	85,537,920.00	85,537,920.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг		
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	(1,693,461,424.98)	(1,836,359,014.02)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг		
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,380,189,877.45	2,237,292,288.41
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,735,202,294.78	3,430,988,306.68

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,994,116,539.75	3,295,808,560.65
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,994,116,539.75	3,295,808,560.65
120	Нийтлэг татварын бус орлого	2,994,116,539.75	3,295,808,560.65
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,323,990,739.75	1,183,063,360.65
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	850,129,850.91	929,698,157.29
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	473,860,888.84	253,365,203.36
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	1,670,125,800.00	2,112,745,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,001,198,126.50	3,438,716,149.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,001,198,126.50	3,438,716,149.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,001,198,126.50	3,438,716,149.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,546,356,033.00	1,693,399,592.43
210101	Үндсэн цалин	1,546,356,033.00	1,693,399,592.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	191,892,560.00	383,171,554.00
210201	Тэтгэврийн даатгал	191,892,560.00	383,171,554.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,018,976.84	36,064,681.13
210301	Гэрэл, цахилгаан	4,562,698.59	15,817,634.93
210302	Түлш, халаалт	11,214,692.25	12,232,059.07
210303	Цэвэр, бохир ус	4,241,586.00	8,014,987.13
2104	Хангамж, бараа материалын зардал	535,125,557.86	642,585,082.15
210401	Бичиг хэрэг	4,288,990.00	6,620,329.74
210402	Тээвэр, шатахуун	483,737,296.50	555,553,409.76
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,388,071.36	21,393,330.76
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	246,500.00	1,560,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	38,464,700.00	57,458,011.89
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	136,276,550.00	58,276,210.34
210604	Урсгал засвар	136,276,550.00	58,276,210.34
2107	Томилолт, зочны зардал	256,000.00	7,240,000.00
210702	Дотоод албан томилолт	256,000.00	7,240,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	192,690,211.83	184,255,542.89
210803	Даатгалын үйлчилгээ	6,869,610.00	8,098,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	6,596,782.00	8,167,594.00
210807	Газрын төлбөр	770,329.00	770,329.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	178,453,490.83	167,218,969.89
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	378,582,236.97	433,723,486.77
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	378,582,236.97	433,723,486.77
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-7,081,586.75	-142,907,589.06
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-7,081,586.75	-142,907,589.06

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

д/д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг алдагдал	Нийт дүн
1	2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	2,841,983,847.16	1,146,129,535.27	85,537,920.00	(2,152,491,461.40)	1,921,159,841.03
2	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
3	Залруулсан үлдэгдэл	2,841,983,847.16	1,146,129,535.27	85,537,920.00	(1,686,369,838.21)	2,387,281,464.22
4	Өмчийн өөрчлөлт					
5	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
6	Тайлант үеийн цэвэр ашиг					
7	Ногдол ашиг					
8	Гаргасан хувьцаат капитал					
9	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,841,983,847.16	1,146,129,535.27	85,537,920.00	(2,152,491,461.40)	1,921,159,841.03
10	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				466,121,623.19	466,121,623.19
11	Залруулсан үлдэгдэл	2,841,983,847.16	1,146,129,535.27	85,537,920.00	-1,693,451,424.96	2,380,199,877.47
12	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
14	Тайлант үеийн цэвэр ашиг				(142,907,589.06)	(142,907,589.06)
15	Ногдол ашиг					
16	Гаргасан хувьцаат капитал					
17	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,841,983,847.16	1,146,129,535.27	85,537,920.00	(1,836,359,014.02)	2,237,292,288.41

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,745,701,913.46	3,325,841,442.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,745,701,913.46	3,325,841,442.57
120	Нийтлэг татварын бус орлого	2,745,701,913.46	3,325,841,442.57
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,075,576,113.46	1,213,096,242.57
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,021,484,650.46	1,202,099,545.25
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	54,091,463.00	10,996,697.32
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	1,670,125,800.00	2,112,745,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,779,265,638.91	3,325,553,548.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,779,265,638.91	3,325,553,548.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,779,265,638.91	3,325,553,548.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,336,692,887.87	1,748,864,046.04
210101	Үндсэн цалин	1,336,692,887.87	1,748,864,046.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	364,994,728.26	402,171,554.00
210201	Тэтгэврийн даатгал	364,994,728.26	402,171,554.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,965,844.30	38,458,011.89
210301	Гэрэл, цахилгаан	31,965,844.30	38,458,011.89
2104	Хангамж, бараа материалын зардал	969,408,378.63	946,277,911.10
210402	Тээвэр, шатахуун	796,711,386.83	807,058,054.62
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	172,696,991.80	139,219,856.48
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	76,203,799.85	189,782,024.97
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	7,367,111.00	118,760,316.88
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	7,341,840.00	8,098,650.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	61,494,848.85	62,923,058.09
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-33,563,725.45	287,894.57
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	27,892,414.00	6,262,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,892,414.00	6,262,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27,892,414.00	6,262,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,892,414.00	6,262,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-27,892,414.00	-6,262,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-61,456,139.45	-5,974,105.43
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	72,566,329.28	11,110,189.83
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,110,189.83	5,136,084.40

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэл

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,112,685,200.00	2,112,685,199.36	0.64	100
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,112,685,200.00	2,112,685,199.36	0.64	100
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,103,229,900.00	2,103,229,899.36	0.00	100
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,869,537,600.00	1,869,537,599.36	0.00	100
210101	Үндсэн цалин	1,090,416,000.00	1,057,686,674.79	32,729,325.21	103.1
210102	Нэмэгдэл	525,021,600.00	557,750,924.77	(32,729,324.77)	94.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	254,100,000.00	254,099,999.80	0.00	100
210104	Урамшуулал	0.00	0.00	0.00	100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	233,692,300.00	233,692,300.00	0.00	100
210201	Тэтгэврийн даатгал	158,910,700.00	158,910,700.00	0.00	100
210202	Тэтгэмжийн даатгал	18,695,400.00	18,695,400.00	0.00	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,956,300.00	14,956,300.00	0.00	100
210204	Ажилгүйдлийн даатгал	3,739,100.00	3,739,100.00	0.00	100
210205	Эрүүл мэндийн даатгал	37,390,800.00	37,390,800.00	0.00	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,455,300.00	9,455,300.00	0	100
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,455,300.00	9,455,300.00	0	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,112,685,200.00	2,112,685,199.36	0	100
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,112,685,200.00	2,112,685,199.36	0	100
132001	Орон нутгийн төсвөөс	2,112,685,200.00	2,112,685,199.36	0	100
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	105	105	0	100
620001	Удирдах ажилтан	1	1	0	100
620002	Гүйцэтгэх ажилтан	103	103	0	100
620003	Үйлчлэх ажилтан	1	1	0	100

2.6 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	2023		зөрүү	хувь	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл			
1	орлого	Борлуулалтын орлого	1,634,341.1	1,183,063.4	(451,277.7)	72.4
		Санхүүжилт	2,112,685.2	2,112,685.2	-	100.0
		Нийт орлого	3,747,026.3	3,295,748.6	(451,277.7)	88.0
2	зардал	Цалин /нэмэгдлийн хамт/	1,706,315.4	1,475,413.7	(230,901.7)	86.5
		Хоол унаа	177,870.0	254,100.0	76,230.0	142.9
		ЭМ,НДШ	235,523.1	383,171.6	147,648.5	162.7
		Засвар үйлчилгээ	64,061.6	58,276.2	(5,785.4)	91.0
		Сэлбэг	86,935.0	81,762.3	(5,172.8)	94.0
		Элэгдэл	377,490.2	433,723.5	56,233.3	114.9
		Тээвэр, даатгал	27,859.9	16,266.2	(11,593.6)	58.4
		Шуудан холбоо	6,456.0	21,393.3	14,937.3	331.4
		Шатахуун	499,995.4	555,553.4	55,558.0	111.1
		Хангамжийн материал	36,794.0	57,458.0	20,664.0	156.2
		Бичиг хэрэг	4,740.5	6,620.4	1,879.9	139.7
		Бусад	85,918.5	35,585.5	(50,333.0)	41.4
		Үйл ажиллагааны бус	105,225.8	59,392.0	(45,833.8)	56.4
		Нийт зардал	3,415,185.3	3,438,716.1	23,530.7	100.7
3	Татварын өмнөх ашиг /алдагдал/	331,841.0	(142,967.5)	-	(43.1)	
4	Татварын зардал	-	-	-	-	
5	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	331,841.0	(142,967.5)	-	(43.1)	

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,619.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагааны орлогыг 12,209.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Санхүүгийн байдлын тайланд 410.0 мянган төгрөгийн авлагын дүнг орхигдуулан тайлагнасан.

Аудитаар нийт 27,208.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 27,208.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу бусад байгууллагаас шилжин ирсэн 38ш тээврийн хэрэгслийг ашиглах боломжгүй дүгнэлт гарсан. Тус тээврийн хэрэгслүүдтэй холбоотой тогтмол зардал /татвар, даатгал болон дугаар солих зэрэг/-ууд гарч байна.	1	-					1	-				
Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	27,208.8			1	27,208.8						
Санхүүгийн "Ноён" программыг 2014 оноос хойш ашиглаж байгаа. Тус программ нь шаардлага хангахгүй, шинэчлэл хийдэггүй зэрэг асуудалтай байна.	1	-					1	-				
Дүн	3	27,208.8			1	27,208.8	2	-				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

²Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийслэлийн Төр захиргааны Автобааз УТҮГ -ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны 4 мэдээллийг хугацаа хоцроосон	1	0.0			1	0.0		
Дүн	1	0.0			1	0.0		